



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

Хэвлэлийн мэдээ

31.07.2019

Холбоо барих

+976 9511 7771

## АмЧам Монгол Америкийн Нэгдсэн Улс, Монгол Улсын хооронд стратегийн түншлэлийн гэрээ байгуулсныг талархан хүлээн авч байна

Монгол Улсын Ерөнхийлөгч Х. Баттулга Америкийн Нэгдсэн Улсад хийсэн айлчлал амжилттай болж хоёр орны хамтын ажиллагаа шинэ шатанд гарч буйг Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол) талархан хүлээн авч байна. Айлчлалын хүрээнд АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамптай Цагаан ордонд ганцаарчилсан уулзалт хийж, өргөтгөсөн хэлэлцээ хийсэн билээ.

Хоёр орны хооронд стратегийн түншлэлийн гэрээ байгуулж тунхаглал гаргасан нь энэхүү айлчлалын гол үр дүн болсон бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч Х. Баттулга хэлэхдээ, "Монгол Улс 192 улстай дипломат харилцаа тогтоосноос өнөөдрийг хүртэл дөрөвтэй нь стратегийн түншлэлтэй байсан. Өнөөдөр ийнхүү АНУ нэмэгдэж байгаад баяртай байна. Монгол, Америкийн харилцаа, хамтын ажиллагааг эдийн засаг, хөрөнгө оруулалт, банк санхүү, худалдааны салбарт харилцан ашигтайгаар өргөжүүлэн хөгжүүлэх боломжтой. Бидний эдийн засгийн хамтын ажиллагаа нэн чамлалттай байгаа гэдэгтэй хоёр тал санал нэг байгаа" гэв.

АНУ нь 16 оронтой Стратегийн түншлэлийн харилцаатай бөгөөд энэ цөөн орны жагсаалтад Монгол Улс нэмэгдэж орлоо. "Стратегийн түншлэлд хүрснээр Монгол Улс бүс нутагтаа АНУ-ын хамгийн ойр түнш нь болж байна," гэж Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар хэлэв. Стратегийн түншлэлийн хүрээнд хоёр орон ардчилсан үнэт зүйлс, сайн засаглал, бүрэн эрхт байдал болон хүний эрхийг дээдлэх зарчмуудад тулгуурлан батжин бэхжиж, энх тайван, аюулгүй, тогтвортой байдлыг дээдэлж, эдийн засгийн хамтын ажиллагаагаа илүү эрчимжүүлж, хөрөнгө оруулалт болон чөлөөт худалдааг дэмжиж, ажлын байр шинээр бий болгох, ядуурлыг бууруулахыг зорьж, соёл, боловсрол, хүмүүнлэгийн болон иргэд хоорондын хэлхээ холбоо зэрэг хамтын ажиллагааг бүхий л салбарт улам бүр өргөжүүлэх боломжууд нээгдэж байгаа билээ.

Монголын ноолууран бүтээгдэхүүнийг АНУ-ын зах зээлд татваргүй экспортлох зорилго бүхий Гуравдагч хөршийн худалдааны тухай хуулийг Конгресст 40 гаруй гишүүн өргөн барьсан бөгөөд айлчлалын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Трампын засаг захиргааны албаны хүмүүстэй уулзаж хуулийн төслийн талаар санал солилцсон юм. Мөн Конгрессын төлөөлөгчдийн танхимиын гишүүн болон Конгресс дахь Америк-Монголын бүлгийн гишүүн Тэд Иохо Ерөнхийлөгч Х. Баттулгад бараалхаж, хоёр улсын тэргүүн нарын уулзалт хуулийн төсөлд томоохон дэмжлэг болсон гэдэгт итгэлтэй байна гэдгээ илэрхийлэв.

Монгол Улсаас АНУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ё. Отгонбаяр хэлэхдээ, "Энэ хууль батлагдсанаар манай улсад 30-50 мянган ажлын байр шууд утгаараа бий болохоос гадна 800 гаруй мянган малчны орлого дээшлэх боломжтой. Түүхий ноолуурын дэлхийн зах зээлийн 45 хувийг Монгол Улс дангаараа, 40 гаруй хувийг нь Хятад улс бэлтгэдэг. Хятадаас АНУ руу орж ирж байгаа барааны татвар нэмэгдэх хандлагатай байна. Харин Гуравдагч хөршийн худалдааны хууль батлагдсанаар Монголоос орж ирж байгаа ноолуурان бүтээгдэхүүний татвар буурна. Бидэнд ноолуураа боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн хийх өргөн боломж бий болж байна. Үүнийг дагаад ажлын байр нэмэгдэнэ, хөрөнгө оруулалт орж ирнэ," гэв.

АмЧам Монгол нь энэхүү хуулийг тууштай дэмжиж ирсэн бөгөөд 2019 оны 6-р сард бизнесийн төлөөлөгчдийн АНУ руу хийсэн айлчлалын үеэр АНУ-ын холбогдох албаны хүмүүстэй уулзаж тус хуулийн талаар ярилцаж дэмжлэг эрэлхийлсэн билээ.

АмЧам Монгол нь цаашид хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар үргэлжлүүлэн идэвхтэй ажиллах болно.

### **АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимиын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимиудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимиудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.

